



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

Үндэсний аудитын газрын
Тамгын дарга, Тэргүүлэх аудитор С.ЦЭРЭНБАЯР


Улаанбаатар хот
2023.12.21



ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА



2023 оны зорилтын хэрэгжилт



- Үндэсний аудитын газар
- Нийслэл дэх Төрийн аудитын газар
- Орон нутаг дах Төрийн аудитын газар
- Нийт

Нийт албан хаагч



Аудитын чиг үүрэг хэрэгжүүлдэг



Захиргаа, бусад чиг үүрэг хэрэгжүүлдэг




АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН




Үр дүнд : 2023 онд төсвөөс авсан нэг төгрөг тутамд 38.3 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон

■ Илрүүлэлт ■ Биелэлт



■ Илрүүлэлт (тэрбум төгрөг) ■ Биелэлт (тэрбум төгрөг)





ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Төрийн аудитын байгууллагын манлайллыг нэмэгдүүлэх, чанарын удирдлагыг төлөвшүүлэх, харилцагч талуудын харилцааг бүхий л түвшинд сайжруулж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийх тогтолцоог төлөвшүүлэх зорилгоор Үндэсний аудитын газрын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцоо, **ISO9001:2015** стандартыг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүллээ.



Чанарын менежментийн тогтолцооны **ISO9001:2015** стандартын анхдагч аудит, баталгаажуулалтыг Франц улсын баталгаажуулалтын байгууллага болох “Афнор” группээр гүйцэтгүүлж, амжилттай хамгааллаа.





ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Европын холбооны санхүүжилттэй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд “Үр дүнд суурилсан төлөвлөлт болон төсөвлөлтийн арга зүй” сургалт-семинарыг 2023 оны 06 дугаар сарын 2-9-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Монгол Улсын төрийн албанд гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсвийн шинэчлэлийг нэвтрүүлж буйтай холбогдуулан

Төрийн аудитын байгууллагын төлөвлөлт болон төсвийг Тогтвортой хөгжлийн зорилт, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын зорилтуудтай уялдуулахад анхаарч,

Төрийн аудитын байгууллагын 2024 оны үйл ажиллагааг үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга хандлагад нийцүүлэн боловсруулсан нь Улсын Их Хурлын харьяа байгууллагуудын хэмжээнд анхдагч болсон төдийгүй бидний цаашдын ажилд бодит үр дүнгээ өгөх чухал ажил болсон юм.





ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 06 Дугаар 65 Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.
- 2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 56 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
- 3.Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



Монгол Улсын Их Хурлын 2023 оны 65 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ / төгрөгөөр/
Амгын дарга	2 980 000
Төрийн аудитын газрын бүтцийн нэгжийн дарга, захирал, эргүүлэх аудитор	2 780 000
Төрийн аудитын газрын хэлтэс, албаны дарга, менежер	2 650 000
Төрийн аудитын газрын ахлах аудитор, ахлах шинжээч	2 530 000
Төрийн аудитын газрын аудитор, шинжээч	2 380 000
Төрийн нутаг дахь Төрийн аудитын газрын дарга	2 650 000
Төрийн нутаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга, аудитын менежер	2 530 000
Төрийн нутаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор, ахлах шинжээч	2 380 000
Төрийн нутаг дахь Төрийн аудитын газрын аудитор, шинжээч	2 130 000

Төрийн аудитын байгууллага цаашид бүтээмжид суурилсан цалин хөлсний тогтолцоог бий болгохоор зорьж байгаа бөгөөд, тайлант хугацаанд Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын цалин хөлсийг дунджаар **64.8** хувиар нэмэгдүүлэн УИХ-ын 2023 оны 65 дугаар тогтоолоор батлууллаа.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО



Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээ (16)

Нийтлэг чадамж (6)

- Удирдан зохион байгуулах
- Дүн шинжилгээ хийх
- Асуудал шийдвэрлэх
- Манлайлах
- Багаар ажиллах
- Харилцаа



Мэргэжлийн ур чадвар (6)

- Аудитын сэдэв тодорхойлох
- Аудитыг төлөвлөх
- Аудитыг гүйцэтгэх
- Аудитын үр дүнг тайлагнах
- Аудитын мөрөөр хяналт тавих
- Аудитын чанарын хяналт хийх

Мэргэжлийн мэдлэг (4)

- Мэргэжлийн болон салбарын хууль, эрх зүйн мэдлэг
- Мэргэжлийн стандартын мэдлэг
- Мэргэжлийн гадаад хэлний чадвар
- Мэдээллийн технологийн чадвар



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО




“Монголын маркетингийн судалгааны ассоциаци” компанийн товч мэдээлэл

ISO 20252:2019
Market, opinion and social research,
including insights and data analytics



ESOMAR-ын судалгааны ёс зүйн стандартыг дэлхий даяар нийт 6000 хувь гишүүн, 130+ орны 550 судалгааны компани мөрдөж байгаагийн нэг нь mscg компани юм




Судалгаа, маркетинг, олон нийтийн санаа бодол, социологийн олон улсын ISO 20252:2019 стандартыг үндэсний хэмжээний стандарт болгон батлуулсан бөгөөд ISO 20252:2019 стандартыг мөрдөн ажилладаг.



Зохиогчийн эрхийн гэрчилгээ



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО



1. Байгууллагын соёлын хэв загвар (order)
2. Бүтээмжийн индекс (72.0%)
3. Албан хаагчдын сэтгэл ханамжийн индекс (63.0%)



Тоон судалгаа:

- Тоон судалгаанд хамрагдсан ажилтны тоо: **322**
- Хамрагдалтын хувь: **70%**
- Асуулгын урт : **15-20 минут**
- Мэдээлэл цуглуулалтыг хийсэн хугацаа:
2023/06/20 – 2023/06/30
- Судалгааг бөглөсөн хугацаа болон, төхөөрөмжийн давхардал, асуулгын бөглөлтөд чанарын шалгалтууд хийгдсэн.
- Аргачлал:
 - CAWI /Computer assistant web interview/ Онлайнаар мэдээлэл цуглуулах арга



Чанарын судалгаа:

- Чанарын хамрагдсан ажилтны тоо: **13 ажилтан**, албан хаагч /Нас, хүйс, ажилласан жил, албан байгууллагаар ялгаатай/
- Асуулгын урт : **50 минут**
- Мэдээлэл цуглуулалтыг хийсэн хугацаа:
2023/06/20 – 2023/07/08
- Аргачлал:
 - CAWI /Computer assistant web interview/ Онлайнаар мэдээлэл цуглуулах арга
 - IDI /In depth interview/ Ганцаарчилсан ярилцлагын арга



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА



Төрийн аудитын байгууллагын сул орон тоог нөхсөн **119**



Төрийн аудитын байгууллагын тангараг өргөсөн **47**



Зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон **151**




Төрийн шагналаар шагнагдсан **27**

Салбарын шагналаар шагнагдсан **21**





ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТ ХӨГЖИЛ






ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТ ХӨГЖИЛ



“Шинэ ажилтныг чиглүүлэх дасан зохицох хөтөлбөр”-ийг шинээр батлуулан хэрэгжүүлж, хөтөлбөрт 26 албан хаагчийг хамрууллаа.





ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТ ХӨГЖИЛ

ADB



“Төрийн аудитын байгууллагын чадавхыг бэхжүүлэх”
АХБ-ны төсөл 2019-2023 он

Аи Ди Аи-н “Аудитын дээд байгууллагуудын
аудиторуудыг мэргэшүүлэх” дэлхий нийтийн чуулга уулзалт
(2023.11.14-15. Лондон хот)

Бүрэлдэхүүн/хийгдсэн ажил	Гэрээлсэн зөвлөх компани
Бүрэлдэхүүн 1: Түншийн үнэлгээ	Австралийн Үндэсний аудитын газар
Бүрэлдэхүүн 2: Төрийн аудитын байгууллагын 5 жилийн цахим мастер төлөвлөгөө	Эрнст Янг компанийн БНЭУ дахь салбар
Тоног төхөөрөмж	Ай Ти Зон ХХК
Бүрэлдэхүүн 3: Сургалт, хөгжлийн стратеги, чадамжийн хүрээ, сургалтын шаталсан хөтөлбөр, цахим сургалтын модулиуд болон сургалтын материал	Английн Төрийн санхүү нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн институт



Азийн Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн Төрийн аудитын байгууллагын чадавхыг бэхжүүлэх төслийг 2019-2023 онд амжилттай хэрэгжүүлж, төслийн хүрээнд Төрийн аудитын байгууллагын ирэх 5 жилийн цахим мастер төлөвлөгөө, сургалтын шаталсан хөтөлбөр болон зарим цахим сургалтын модулиудыг олон улсын байгууллага болон зөвлөхүүдтэй хамтран боловсруулж хүлээж авсан.

“Тогтвортой аудитын үйл ажиллагаа” чөлөөт хэлэлцүүлэгт панелистаар оролцож

- Монгол Улсын Төрийн аудитын байгууллага тогтвортой аудитын үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ
- хууль эрхзүйн хүрээнд Төрийн аудитын тухай хууль болон бусад холбогдох хуулиудад оруулсан өөрчлөлтүүд талаар мэдээлэл өгөв.




МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ХӨГЖИЛ

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд төрийн салбарын мэдээллийн технологийн ололт амжилтыг нэвтрүүлэхэд анхаарч:



Үндэсний дата төвөөс хэрэгжүүлж байгаа “Төрийн үүлэн дэд бүтэц”-д нэгдэн, нөөц дэд бүтцийг үүсгэх ажлыг хэрэгжүүлсэн нь программ хангамжийн гэмтэл, саатлын эрсдэлийг бууруулах, туршлага мэдээллээ солилцох боломжоор хангасан үр дүнтэй байлаа.

Түүнчлэн санхүүгийн болон гүйцэтгэл-нийцлийн аудитын үйл ажиллагаанд ашиглах программуудыг хөгжүүлэх, нэвтрүүлэх, сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, албан хаагчдыг компьютер, техник хэрэгслээр хангах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.






АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ



Сонгон шалгаруулалт





АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Үндэсний аудитын газрын архивд баримтын нягтруулсан шүүгээ **13**



DVD, CD хадгалах зориулалтын шүүгээ **1**



Архивын чийг дулаан хэмжих багаж **2**



Байгууллагын архивд хадгалах хугацаа дууссан **940** боть баримтыг Үндэсний төв архивд стандартын дагуу шилжүүлж, баримтын хадгалалт, хамгаалалтын орчин нөхцөлийг сайжрууллаа.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД



Австрали Улс болон Бүгд Найрамдах Индонез Улсын Аудитын дээд байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсэг 2023 оны 03 дугаар сарын 05-аас 15-ний өдрүүдэд Үндэсний аудитын газарт ажиллаж Түншийн үнэлгээг аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.



Тус ажлын хэсгээс Түншийн үнэлгээний тайланг 2023 оны 05 дугаар сард хүлээн авч, үнэлгээний мөрөөр холбогдох сайжруулалтуудыг хэрэгжүүлж байна.




ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД



Монгол Улсын Ерөнхий аудитор болон удирдлагууд 2023 онд Япон улс, БНХАУ, БНСУ-ын Аудитын дээд байгууллагуудад албан айлчлалыг зохион байгуулж, тус улсын Аудитын дээд байгууллагуудтай Хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан нь гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлсэн чухал арга хэмжээ болсон.



Монгол Улсын Ерөнхий аудитор
Д.Занданбат, БНХАУ-ын Үндэсний
аудитын газрын Ерөнхий аудитор Хоу
Кай-н хамт



Үндэсний аудитын газар болон
БНХАУ-ын Үндэсний аудитын газар
хоорондын хоёр талт уулзалтад
оролцсон төлөөлөгчид



Монгол Улсын Ерөнхий аудитор
Д.Занданбат Япон Улсын Аудитын
зөвлөлийн Ерөнхийлөгч, Морита
Юүжигийн хамт



Үндэсний аудитын газрын төлөөлөгчид
Япон улсын Аудитын зөвлөлийн
төлөөллийн хамт



ШИНЭ ОНЫ ЗОРИЛТ



Төрийн аудитын байгууллагаас улс орны ирээдүйн хөгжлийг хангах алсын хараатай, зөв шийдвэрийг гаргахад УИХ, Засгийн газарт дэмжлэг болохуйц, болзошгүй эрсдэлээс сэргийлсэн, үр нөлөөтэй аудитыг гүйцэтгэх, аудитын үр дүнд бий болох үр өгөөжийг дээшлүүлэх явдал юм.



Босоо хэлбэртэй байсан хариуцлагын тогтолцоо хэвтээ болж ард иргэд, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хамтарсан хяналт оролцоо, ил тод байдал дээр тулгуурладаг болж байгаа өнөө цаг үед Төрийн аудитын байгууллагын манлайллыг нэмэгдүүлэх, орчноо соргог мэдрэх, ажлын арга хандлагаа цаг үедээ нийцүүлэн өөрчлөн сайжруулах, үргэлж суралцах, бүтээмжийг дэмжих чиглэлд түлхүү анхаарч, хурдтай ажиллах шаардлага бий болж байна.



Хүний нөөцийн чадавх, туршлага болон аудит хийлгэж буй байгууллагын шинж чанарт нийцүүлж, аудитын багийн зохион байгуулалтыг оновчтой төлөвлөх, ажлын ачааллыг жигд, тохиромжтой хуваарилж удирдах, аудитын ажлын үе шатны хяналтуудыг чанартай гүйцэтгэх зэрэг удирдах түвшний албан хаагчдын хянан удирдах чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулах бодит хэрэгцээ шаардлага бий болсон байна.



ШИНЭ ОНЫ ЗОРИЛТ



Сонгуулийн шинэ тогтолцооны гарааны жил учраас улс төрийн намууд, нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдийг Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн зорилтууд болон холбогдох хуулиудтай хэрхэн нийцэж байгааг бодитой хянах, төсөв тооцоолол сайтай, ирээдүйд улсын болоод орон нутгийн хөгжилд хувь нэмэр болохуйц зорилго зорилтыг зөв тодорхойлж чадсан мөрийн хөтөлбөрүүдийг дэмжиж дүгнэлт гаргах хэрэгцээ хүлээлт бидний өмнө байна.



ШИНЭ ОНЫ ЗОРИЛТ



2023 онд гүйцэтгэсэн гүйцэтгэл,
нийцлийн аудит



Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллагын Хөгжлийн санаачилга (Аи Ди Аи) болон Монгол Улсын аудитын дээд байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд Гүйцэтгэлийн аудитад АДБОУС-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж буйд үнэлгээ хийх төслийг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хөтөлбөрийн II үе шатанд Аудитын дээд байгууллагын аудиторуудын мэргэжлийн боловсрол (ПЕСА)-д аудиторуудыг хамруулах, аудитын чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, аудитын мөрөөр гүйцэтгэх үйл ажиллагааг сайжруулах, АДБОУС-д нийцсэн гүйцэтгэлийн аудитын арга зүй хөгжүүлэх, туршилтын аудит хийх зэрэг 7 чиглэл бүхий ажлыг 2024-2025 онд зохион байгуулж хэрэгжүүлэхээр тогтоод байна.



ШИНЭ ОНЫ ЗОРИЛТ



2024 онд Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр Австрали, БНСВУ, Унгар улсын Аудитын дээд байгууллагуудтай хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, Кувейт, Турк зэрэг улс орны аудитын дээд байгууллагуудтай өмнө хэрэгжүүлж байсан харилцаа, хамтын ажиллагааг сэргээх, олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг бий болгохыг зорьж ажиллах юм.



ДУГНЭЛТ



Бид өөрийн дотоод нөөц боломж, туршлага, сургамжид тулгуурлан, улс орнуудын аудитын дээд байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд тэдний тэргүүн туршлага, арга барилаас суралцах замаар улс, нийгмийн бүх салбарт тулгарах эрсдэлийг удирдах тогтолцоог бий болгож, түүнд чиглэсэн шинэ зорилт, агуулгаар АУДИТЫГ гүйцэтгэх, аудитын үр өгөөжийг нэмэгдүүлэх, аудитын дэмжих үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, менежментийн тогтолцоогоо сайжруулах шаардлагын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах юм.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

Төрийн аудитын байгууллагын
2023 оны үйл ажиллагаа, үр дүн